



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК-ИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/101/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 51-261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: С.Батэрдэнэ
Утас: 51-261740 Цахим хаяг: bat-erdenes@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр хийж гүйцэтгэсэн:
Ди Эй Би Жи Аудит ХХК
Захирал Н.Дэлгэрмаа
Утас: 976-91910954 Цахим хаяг: dabg.audit@yahoo.com

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	7
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	15
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	16
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
8. Аудитын илрүүлэлт	18
8.1 Төлбөрийн акт.....	18
8.2 Албан шаардлага	18
8.3 Зөвлөмж.....	19
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд байгууллагын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЭХС	Эрчим хүчний сайд
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.БАЛЖИННЯМ ТАНАА

2022.03.15 № 07/521
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

1. Эрчим хүчний зохицуулах хороо нь баталсан төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээ тайланд үндэслэн дараа сард, оны дундуур тариф, мөнгөн урсгалын коэффициентод зохицуулалт хийгээгүйгээс нэг худалдан авагчийн загварын тайланд завсрын аудитаар 16,484.8 сая, жилийн эцэст 2,374.6 сая төгрөгийн зэрэг зөрүүг тайлагнасан байна. Тариф болон мөнгөн урсгалын коэффициентыг баталж мөрдүүлж байгаа нь нэг худалдан авагчтай загварыг ашиглан эрчим хүчний салбарын ашиг алдагдлыг тэнцүүлэх зорилготой боловч өмнөх жилүүдэд зэрэг, сөрөг зөрүүнүүдийг тайлагнаж, Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн нэгтгэсэн тайланд өртгийг өсгөж, бууруулах зөрчилдсөн нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байна.

2. Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгч байгууллагатай 2015 оноос өмнө байгуулсан гэрээнд “take or pay” хатуу нөхцөлийн дагуу дутуу нийлүүлсэн буюу худалдан аваагүй эрчим хүчний төлбөрийг төлж, үүнээс шалтгаалан өртөг өсөж, хэрэглэгчдийн эрчим хүчний хэрэглээний үнэ нэмэгдэх нөхцөл бүрдсэн байна. 2021 онд дутуу нийлүүлсэн цахилгаан эрчим хүч болох 4752.2 мян.кВт цагийн төлбөрт 1,414.9 сая төгрөгийн төлбөрийг бүртгээгүй, төлөөгүй боловч маргаантай асуудлыг олон улсын гэрээ болон дээд шатны байгууллагууд шийдвэрлэхээр байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 12 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ, боловсруулалт 107.8 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрх болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан дулааны эрчим хүчний төлбөрийг зохих журмын дагуу төрөөс хариуцан төлөх болсонтой холбоотой эрчим хүчний хэрэглээ өссөн байна.

Нийт орлого төлөвлөснөөс 130.3 сая төгрөгөөр буюу 101.3 хувиар давж биелсэн нь үйл ажиллагааны бус орлого нэмэгдсэнтэй холбоотой. Харин борлуулалтын орлого 99.8 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь диспетчерийн зохицуулалтын тарифыг баталсан төлөвлөгөөнөөс 19.7 сая төгрөгөөр бууруулан тогтоосноос шалтгаалжээ.

Нийт зардал 76.8 хувийн гүйцэтгэлтэй 680.9 сая төгрөгийг хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, үйл ажиллагааны зардалд хэмнэлт гаргасан байна.

Хөрөнгө оруулалтаар нийт 23 ажилд 3,194.1 сая төгрөгийн гэрээ байгуулж, 98.1 хувийн гүйцэтгэлтэй, 61.3 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,870,331,637.05	4,484,937,901.58
1.1.2	Дансны авлага	70,628,924,368.11	91,384,295,595.78
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,330,985,204.57	1,305,784,093.91
1.1.4	Бусад авлага	49,993,000.00	7,725,000.0
1.1.6	Бараа материал	186,451,958.96	245,034,279.77
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	54,524,128.23	102,205,415.27
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	77,121,210,296.92	97,529,982,286.31
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,718,933,413.09	9,352,664,560.47
1.2.2	Биет бус хөрөнгө	2,336,667,354.90	3,001,816,424.44
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө		1,077,298,666.77
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,055,600,767.99	13,431,779,651.68
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	89,176,811,064.91	110,961,761,937.99
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	66,270,025,745.41	93,086,414,936.55
2.1.1.3	Татварын өр	1,921,576,230.52	320,612,266.71
2.1.1.4	НДШ–ийн өглөг	-	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	341,851,387.51	21,535,035.75
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	10,857,838,354.05	3,868,442,772.71
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	79,391,291,717.49	97,297,005,011.72
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	
2.1.2.1	Урт хугацаат зээл	7,511,811,646.36	6,789,019,436.04
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	9,238,124,756.07	914,652,709.34
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	16,749,936,402.43	7,703,672,145.38
2.2	Өр төлбөрийн нийт дүн	96,141,228,119.92	105,000,677,157.09
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,811,705,231.02	1,811,705,231.02
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	587,815,153.11	587,815,153.11
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	3,406,082.55	140,628,482.55
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(9,367,343,521.69)	3,420,935,914.22
2.3.11	Эздийн өмчийн дүн	(6,964,417,055.01)	5,961,084,780.90
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	89,176,811,064.91	110,961,761,937.99

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	894,915,307,659.65	1,016,556,113,363.31
2	Борлуулалтын өртөг	895,627,822,855.50	1,018,921,869,615.36
3	Нийт ашиг (алдагдал)	(712,515,195.85)	(2,365,756,252.05)
4	Хүүний орлого	140,144,408.30	907,383.99
5	Бусад орлого	3,557,408,864.86	7,209,103,082.21
6	Борлуулалт, маркетингийн зардал	461,266,521.01	441,948,581.48
7	Ерөнхий ба удирдлагын зардал	1,216,202,540.28	1,361,982,336.46
8	Санхүүгийн зардал	147,929,175.14	141,384,307.45
9	Бусад зардал	552,827,639.81	1,252,928,176.45
10	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(454,698,498.79)	(14,554,310.11)
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		818,181.82
12	Бусад ашиг (алдагдал)	8,993,481.76	-
13	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	161,107,184.04	1,632,274,684.02
14	Орлогын татварын зардал	35,057,780.82	284,336,397.00
15	Татварын дараах ашиг (алдагдал)	126,049,403.22	1,347,938,287.02
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	126,049,403.22	1,347,938,287.02

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	3,406,082.55	(7,857,108,779.08)	(5,454,182,312.40)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(1,636,284,145.83)	(1,636,284,145.83)
Залруулсан үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	3,406,082.55	(9,493,392,924.91)	(7,090,466,458.23)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				126,049,403.22	126,049,403.22
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	3,406,082.55	(9,367,343,521.69)	(6,964,417,055.01)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			137,222,400.00	11,440,341,148.89	11,577,563,548.89
Залруулсан үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	3,406,082.55	(9,367,343,521.69)	(6,964,417,055.01)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				1,347,938,287.02	1,347,938,287.02
Зарласан ногдол ашиг					
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	140,628,482.55	3,420,935,914.22	5,961,084,780.90

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	758,259,041,151.89	971,418,710,798.83
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	756,223,408,492.77	970,903,829,734.28
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	
	Бусад мөнгөн орлого	2,035,632,659.12	514,881,064.55
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	757,912,626,759.90	967,815,931,312.77
	Ажиллагчдад төлсөн	3,537,712,771.19	3,248,553,122.61
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	881,837,931.46	852,889,037.03
	Бараа материал худалдан авахад төлсөн	745,096,994,511.84	946,777,021,852.39
	Ашиглалтын зардалд төлсөн	559,342,084.13	561,013,052.46
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	47,527,423.01	40,575,144.00
	Хүүний төлбөрт төлсөн	366,943,779.73	141,384,307.45
	Татварын байгууллагад төлсөн	7,213,450,380.19	15,350,836,043.59
	Даатгалын төлбөрт төлсөн	8,870,175.11	7,935,795.00
	Бусад мөнгөн зарлага	199,947,703.24	835,722,958.24
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	346,414,391.99	3,602,779,486.06
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	140,235,698.54	1,807,383.99
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	900,000.00
	Хүлээн авсан хүүний орлого	140,235,698.54	907,383.99
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,845,488,541.23	3,222,402,570.15
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,609,361,716.38	1,417,280,390.62
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	236,126,824.85	1,805,122,179.53
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,705,252,842.69)	(3,220,595,186.16)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	23,179,273.72	4,959,333.23
	Бусад	23,179,273.72	4,959,333.23
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	655,549,503.94	772,537,368.60
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	609,051,778.93	722,792,210.39
	Төлсөн ногдол ашиг	25,334,345.00	37,814,820.96
	Бусад	21,163,380.01	11,930,337.25
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(632,370,230.22)	(767,578,035.37)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,991,208,680.92)	(385,393,735.47)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,861,540,317.97	4,870,331,637.05
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,870,331,637.05	4,484,937,901.58

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цахилгаан эрчим хүч:	Нийт хэрэглээ /боловсруулалтаар/	сая.кВтц	7,290.0	7,858.9	568.9	107.8
		Боловсруулалт	сая.кВтц	6,950.0	7,483.5	533.5	107.7
		Түгээлтээр	сая.кВтц	6,128.4	6,659.5	531.2	108.7
	Дулааны эрчим хүч:	Боловсруулалт	мян.Гкал	9,489.4	9,377.0	(112.4)	98.8
		Түгээлтээр	мян.Гкал	9,215.3	9,136.2	(79.1)	99.1
2	Нийт орлого		төгрөгөөр	10,103,278,436.14	10,233,544,086.44	130,265,650.30	101.3
	Үүнээс:	Борлуулалтын орлого	төгрөгөөр	9,778,418,436.14	9,758,725,899.92	(19,692,536.22)	99.8
		Үйл ажиллагааны бус орлого	төгрөгөөр	324,860,000.00	474,818,186.52	149,958,186.52	146.2
3	Нийт зардал		төгрөгөөр	10,100,175,148.85	8,586,164,362.05	(1,514,010,786.80)	85.0
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	төгрөгөөр	8,442,748,956.85	7,236,135,645.32	(1,206,613,311.53)	85.7
		Хөрөнгө оруулалтын өгөөжийн зардал	төгрөгөөр	1,339,858,192.00	923,275,675.10	(416,582,516.90)	68.9
		Үйл ажиллагааны бус зардал	төгрөгөөр	317,568,000.00	426,753,041.63	109,185,041.63	134.4
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		төгрөгөөр	3,103,287.29	1,647,379,724.39	1,644,276,437.10	53,085.0
5	Татварын дараах ашиг /алдагдал/		төгрөгөөр	2,792,958.56	1,363,132,384.95	1,360,339,426.39	48,806.0
6	Борлуулалтын орлогын 1 төгт ногдох зардал		төгрөгөөр	1.00	0.89	(0.11)	88.9
7	Нийт авлага		төгрөгөөр	150,000,000.00	645,229,740.00	495,229,740.00	430.2
	Үүнээс:	ЭХ-ний бусад	төгрөгөөр	-	458,784,133.00	458,784,133.00	-
бусад		төгрөгөөр	150,000,000.00	186,445,607.00	36,445,607.00	124.3	
8	Нийт өглөг		төгрөгөөр	9,141,700,000.00	8,236,662,461.38	(905,037,538.62)	90.1
	Үүнээс:	УХӨТ	төгрөгөөр	8,630,144,992.32	7,703,672,145.38	(926,472,846.94)	89.3
		БХӨТ	төгрөгөөр	511,555,007.68	532,990,316.00	21,435,308.32	104.2
9	Нийт ажилчдын тоо		тоо	106	106	-	100.0
10	Нийт цалингийн сан		төгрөгөөр	3,800,871,249.09	3,138,932,935.71	(661,938,313.38)	82.6
11	Диспетчерийн үр ашигтай зохицуулалт, горим төлөвлөлт		төгрөгөөр	115,590,000.00	116,330,000.00	740,000.00	100.6
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		төгрөгөөр	3,255,368,400.00	3,194,079,200.00	(61,289,200.00)	98.1
	Үүнээс:	Их засвар	төгрөгөөр	35,254,400.00	29,691,200.00	(5,563,200.00)	84.2
		ТЗБАХ	төгрөгөөр	125,985,000.00	124,424,000.00	(1,561,000.00)	98.8
		Хөрөнгө оруулалт	төгрөгөөр	3,094,129,000.00	3,039,964,000.00	(54,165,000.00)	98.2

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад өртөг зардлуудыг өртгийн төвүүдээр зөв хуваарилан бүртгэх, нэмэлт ажил үйлчилгээний цэвэр ашгийг зөв тооцоолон хуваарилах, татварын өр, авлагыг баталгаажуулан тайлагнахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 10-аас 2022 оны 03 дугаар сарын 10-ны хооронд Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн Захирал Н.Дэлгэрмаа, аудитор Ө.Ундармаа С.Цэнгэлмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Эрдэнэчимэг хэрэгжүүлсэн.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ЭХЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2021 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд шалгалт хийж хэрэгжилтийг 100 хувь гэж үнэлсэн байна.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн санхүүгийн хяналтын ажилтан нь гүйцэтгэх захирлаар жилийн төлөвлөгөөг батлуулж, нийт 44 ажлыг гүйцэтгэсэн байна. Аудитын явцад санхүүгийн хяналтын ажилтнаас ирүүлсэн нэмэлт ажил үйлчилгээний зардлын тооцоолол, валютын ханшийн зөрүүгийн тооцоолол, борлуулсан бүтээгдэхүүний өртөг болон ерөнхий удирдлагын зардлын өртгийн төвөөр хуваарилсан тооцооллуудын үнэн зөв байдлыг үнэлсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 898,612.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,986.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн үндсэн зорилго нь оновчтой зохицуулалт, чанартай эрчим хүчийг үндэсний хэмжээнд бүрэн хангаж ажиллахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “Нэгдсэн сүлжээний дүрэм”-ийн хүрээнд цахилгаан үйлдвэрлэх, импортлох, дамжуулах, түгээх, нийслэл төвлөрсөн дулаан хангамж бүхий хотуудын дулаан үйлдвэрлэх, дамжуулах үйл ажиллагааг диспетчерийн шуурхай зохицуулалтаар удирдах;
- Цахилгаан, дулаан үйлдвэрлэлийн хэмнэлттэй горим төлөвлөгөөг хэрэгжүүлж, нэгдсэн сүлжээний хүрээнд арилжааны үйл ажиллагааг удирдах;
- Салбарын хэмжээнд реле хамгаалалт, автоматикийн байгууламжид хяналт тавьж, системийн тогтвортой ажиллагааг хангахад үнэлэлт, дүгнэлт гаргаж, холбогдох арга хэмжээг авах;
- Үйлдвэрлэгч, дамжуулагч компаниудын технологийн үйл ажиллагааны хяналт мэдээллийн СКАДА системийн тоног төхөөрөмж, компьютерын программ, техник хангамж, диспетчерийн шуурхай холбоо, мэдээллийн сүлжээний бэлэн байдлыг хангаж шинэ техник, технологи нэвтрүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Нэгдсэн сүлжээний арилжааны үйл ажиллагааг удирдан явуулна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс Эрчим хүчний яам 70.0 хувь, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 30.0 хувийг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Диспетчерийн үндэсний төв Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг Улсын Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай;

Компанийн гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-аас томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.9 дэх заалт, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.7 заалттай;

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 102,831.0 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ

нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай тус тус нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Гүйцэтгэх захирлын 2021 оны А/137 дугаар тушаалаар байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн баталж мөрдүүлж байна. Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны 01122-А/767/2021 шийдвэрийн дагуу 137.2 сая төгрөгийн өртөгтэй 1021 м2 Үйлдвэрийн албан конторын зориулалттай газрыг Эрчим хүчний яамнаас шилжүүлэн баланс тайланд тусгах арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3 дах заалтад нийцүүлэн Эрчим хүчний салбарын бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгохоор Эрчим хүчний сайдын 2021 оны а/208 дугаар албан бичгийн дагуу Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-аас Техник хяналтын нэгжийг Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн бүтцэд оруулж 15 орон тоог шилжүүлсэн, ЭХЯ болон ЭХЗХ-оос өгсөн чиглэлийн дагуу Эрчим хүчний салбарын мэдээлэл технологийн төвийг шинээр байгуулан, ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар тогтоолыг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2021 оны Б/98 дугаар тушаалаар бүтцийг өөрчилж, 123 орон тоогоор ажиллахаар баталсан ч 106 орон тоогоор ажиллаж орон тоог 17-оор бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн Газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,870.3	4,484.9	(385.4)
Дансны авлага	70,678.9	91,392.0	20,713.1
Татварын авлага	1,331.0	1,305.8	(25.2)
Урьдчилгаа	54.5	102.2	47.7
Бараа материал	186.5	245.0	58.6
Үндсэн хөрөнгө	9,718.9	9352.7	(366.2)
Биет бус хөрөнгө	2,336.7	3,001.8	665.1
Бусад эргэлтийн бус хөрөнгө		1,077.3	1,077.3
Нийт хөрөнгийн дүн	89,176.8	110,961.8	21,785.0
Богино хугацаат өр төлбөр	79,391.3	97,297.0	17,905.7
Урт хугацаат өр төлбөр	16,749.9	7,703.7	(9,046.2)
Эздийн өмч	(6,964.4)	5961.1	12,925.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	89,176.8	110,961.8	21,785.0

Касс дахь бэлэн мөнгө 4.9 сая, банкин дахь диспетчерийн зохицуулалтын үйл ажиллагааны харилцах дансанд 2,515.1 сая, экспорт импортын үйл ажиллагааны харилцах дансанд 1,969.8 сая, нийт 4,484.9 сая төгрөг байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,484.9 сая төгрөг болж 385.4 сая төгрөгөөр буурсан нь 2015-2018 онуудын дутуу төлсөн татварын маргааныг Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэж нийт 806.2 сая төгрөгийн актын төлбөрийг төлж барагдуулсантай холбоотой байна.

Авлагын үлдэгдэлд дансны авлага 91,384.0 сая, татварын авлага 1,305.8 сая, бусад авлага 7.7 сая төгрөг тус тус эзэлж байна. Дансны авлагын үлдэгдэлд диспетчерийн зохицуулалтын орлогын дутуу төвлөрүүлэлт 458.8 сая, нэг худалдан авагчийн загварын тооцооны авлага 90,835.6 сая, экспортын авлага 89.8 сая төгрөг тус тус тайлагнасан байна. Татварын авлагын дүнд диспетчерийн үйл ажиллагааны тайланд 178.7 сая, нэг худалдан авагчийн загварын тайланд 1,127.1 сая төгрөгийн НӨАТ-ын татварын авлагын үлдэгдэл байна.

Тайлант онд Нэг худалдан авагчтай загварын тайлангийн хүрээнд үүссэн дансны авлага 20,687.9 сая төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлын улмаас хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэхгүй байгаа тул томоохон хэрэглэгчдийн авлага өссөн, мөн цахилгааны суурь зардлыг төрөөс даах болсонтой холбоотой 10,11 дүгээр сарын санхүүжилт 11,679.5 сая дутуу ,12 дугаар сарын 111,414.7 сая төгрөгийн санхүүжилт он дамжин орж ирээгүй нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Бусад авлага 7.7 сая төгрөг болж 42.3 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулснаас шалтгаалжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 92,697.8 сая төгрөг, үүнээс нэг худалдан авагчийн загварын тайланд УБЦТС ТӨХК, ЭБЦТС ТӨХК-ийн 79,009.3 сая төгрөгийн авлага нь Засгийн газрын төрөөс даах, Агаарын бохирдлын сан, Эрдэнэт үйлдвэр болон бусад аж ахуйн нэгжүүдийн санхүүжилт дутуу төвлөрсөнтэй холбоотой байна. Найдваргүй авлагыг шууд аргаар тооцдог, тайлант онд нөөц байгуулаагүй, данснаас хассан авлагагүй байна.

Тайлант онд 2019 оны төлөвлөгөөнд батлагдсан шинээр баригдах барилгын техникийн нөхцөл, зураг төсвийн ажлын төлбөрт 102.0 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2020 онд шилжүүлсэн Эрчим хүчний системийн диспетчерийн шуурхай ажиллагааны онлайн систем программын 54.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг тайлант онд дүгнэн, акт үйлдэж биет бус хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 245.0 сая төгрөг болж 58.6 сая төгрөгөөр өссөн нь өмнөх оны аудитаас өгсөн албан шаардлагын дагуу үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан 67.0 сая төгрөгийн аваарын сэлбэгийг бараа материалд шилжүүлснээс шалтгаалжээ.

Тайлант онд 153.5 сая төгрөгийн худалдан авалт, 67.0 сая төгрөгийн хөрөнгийн ангилал шилжүүлэн бүртгэсэн дүнгээр нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд 2 жилээс дээш насжилттай Скада тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл 92.1 сая төгрөг, аваарын нөөцийн 118.7 сая төгрөгийн бараа материал байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013 онд төсөл хэрэгжүүлэх үед Скада тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, 2017-2019 онуудад нөөцийн хөрөнгийг их хэмжээгээр бэлтгэсэн нь ашиглалт багатай нөөцийг үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 1,197.7 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны А-1/1955 дугаар албан бичиг, 585 дугаар тогтоолоор нийт 53.8 сая төгрөгийн үлдэх өртөггүй 39 ширхэг хөрөнгийг акталсан, А-1/782 дугаар тогтоолоор 67.0 сая төгрөгийн

өртөгтэй 22 ширхэг хөрөнгийг бараа материалын нөөцийн дансанд шилжүүлсэн дүнгээр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 1,861.6 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан 154.5 сая төгрөгийн диспетчерийн шуурхай ажиллагааны онлайн систем, 711.1 сая төгрөгийн шилжилтийн горимын хяналт мэдээллийн WAMS системийн өргөтгөл, 532.1 сая төгрөгийн хяналт мэдээллийн систем, 149.8 сая төгрөгийн худалдан авалтын тооцоог тоолуурын нэгдсэн системийг ашиглан хийх боломжийг бүрдүүлэх, өргөтгөл, шинэчлэл болон 176.8 сая төгрөгийн бусад лиценз болон Эрчим хүчний яамнаас 137.2 сая төгрөгийн газар эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэн бүртгэснээс шалтгаалжээ.

Бусад эргэлтийн бус хөрөнгөнд 1,077.3 сая төгрөгийн нэг худалдан авагчийн загварын тайлангийн тарифын сөрөг зөрүүгээс үүссэн болзошгүй хөрөнгийг бүртгэсэн байна. Тарифын эерэг, сөрөг зөрүүг 2016 оноос өссөн дүнгээр залруулан тайлагнасан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд нэг худалдан авагчтай загварын тайлангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн өглөг 93,086.4 сая, компанийн их засвар, хөрөнгө оруулалтын ажлын барьцаа 282.1 сая, татварын өр төлбөр 320.6 сая, урьдчилж орсон орлого 21.5 сая, экспорт импортын үйл ажиллагааны өр төлбөр 3,586.3 сая, нийт 97,297.0 сая төгрөгийн өр төлбөр байна.

Нэг худалдан авагчийн загварын тооцооны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дансны өглөг 25,605.7 сая төгрөгөөр буюу 37.9 хувиар өссөн нь цахилгаан эрчим хүчний төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтөөс шалтгаалан хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ өссөнтэй холбоотой байна.

Татварын өрийн үлдэгдэлд 2021 оны ААНОАТ-ын 229.3 сая төгрөг, гаалийн албан татварын 91.3 сая төгрөгийн өр төлбөр байна.

Импортын өр төлбөр 6,999.8 сая төгрөгөөр буурсан нь Оросын холбооны улсаас худалдаж авсан цахилгаан эрчим хүчний импортын хуримтлагдсан өрийг тайлант онд барагдуулснаас гадна 12 дугаар сарын худалдан авалтын төлбөрийг урьдчилан төлснөөс шалтгаалсан байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 2002, 2008 онуудад 2 үе шаттай Германы сэргээн босголтын банкнаас авсан Эрчим хүчний салбарын хөтөлбөр-1 төслийн “Төвийн эрчим хүчний шинэ систем байгуулах”, “Тоолуурын автомат мэдээллийн систем байгуулах”, “Скада системд IEC104 протоколын өргөтгөл хийх” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээс үүссэн 11,409.3 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрөөс 4,620.2 сая төгрөг төлөгдсөн, 6,789.1 сая төгрөгийн хэвийн зээл байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013 онд Төвийн эрчим хүчний диспетчерийн шинэ систем байгуулахад 2,948.1 сая, Таван бүсийн хяналт мэдээллийн Скада системийг байгуулахад 522.3 сая, 2017 онд Төвийн эрчим хүчний системийн тоолуурын нэгдсэн системийн өргөтгөлд 524.1 сая төгрөгийг тус тус санхүүжүүлснийг хойшлогдсон орлогоор бүртгэж, өнгөрсөн хугацаанд 3,079.9 сая төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрч үлдэгдэл 914.6 сая төгрөгийг тайлагнасан байна.

Эздийн өмчийн бусад хэсэг дансанд Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны 01122-А/767/2021 шийдвэрийн дагуу 137.2 сая төгрөгийн өртөгтэй 1021 м² үйлдвэрийн албан конторын зориулалттай газрыг Эрчим хүчний яамнаас шилжүүлэн авч, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу үнэлж бүртгэсэн байна.

Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг дансанд 10,614.2 сая төгрөгийн өмнөх үеийн алдааны залруулга бүртгэсэн нь нэг худалдан авагчтай загварын тайланд 2016-2019 онуудын тарифын зөрүү 11,510.8 сая төгрөгөөр алдагдлыг бууруулан, өмнөх оны графикийн хазайлтын зөрүүг илүү тооцсон 4.6 сая төгрөгөөр алдагдлыг нэмэгдүүлэн, өмнөх онд

нэмэлт ажил үйлчилгээний орлогыг илүү тайлагнасан 14.9 сая, сэлбэгийн зардал тайлагнаагүй 13.2 сая, ногдол ашгийн төлбөр 37.8 сая төгрөгөөр алдагдлыг нэмэгдүүлэн залруулснаас тус тус шалтгаалжээ.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлын чиг үүргийн аргаар ангилж, өртгийн төвүүдээр хуваарилан орлого, зардал зохицох зарчмаар хүлээн зөвшөөрч, аккруэл суурьт үндэслэн өртгөөр нь үнэлэн тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий ба удирдлагын зардал, борлуулалт маркетингийн зардал, санхүүгийн зардал, бусад зардал гэж ангилсан байна.

Өмнөх онтой харьцуулахад борлуулсан бүтээгдэхүүний өртөг 123,294.1 сая, ерөнхий ба удирдлагын зардал 145.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, борлуулалт маркетингийн зардал 19.4 сая, санхүүгийн зардал 6.5 сая, бусад зардал 126.0 сая төгрөгөөр тус тус буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 123,294.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь цахилгаан эрчим хүчний хэрэглээ 14.0 хувиар өссөн, 12 дугаар сард энергийн тариф нэмэгдсэн;
- Ерөнхий ба удирдлагын зардалд байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийлгэж бодлогын баримт бичгүүд боловсруулах зөвлөх үйлчилгээний төлбөр 97.1 сая, конторын барилгын өртөг нэмэгдсэнээс элэгдлийн зардал 43.5 сая төгрөгөөр тус тус өссөн;
- Борлуулалт маркетингийн зардал 19.4 сая төгрөгөөр буурсан нь сурталчилгааны зардлаас 8.2 сая төгрөг, бусад зардлаас 11.2 сая төгрөг хэмнэсэн;
- Санхүүгийн зардал 6.5 сая төгрөгөөр буурсан нь урт хугацаат зээлийн хүүгийн зардал хуваарийн дагуу жил ирэх тусам буурч байгаа;

Бусад зардал өмнөх оны мөн үеэс 126.0 сая төгрөгөөр буурсан нь баяр ёслолын 54.6 сая, спортын арга хэмжээний зардал 11.5 сая, шагнал урамшуулал 44.7 сая, нийгмийн арга хэмжээний зардал 15.2 сая төгрөгөөр тус тус буурсан.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлдэг алба, нэгжүүдийг өртгийн төв болгон үйл ажиллагаатай нь холбогдон гарах зардлуудыг хамруулсан нь НББОУС 1.103 заалттай нийцсэн байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 30 дугаар тогтоол, ЭХС-ын 2021 оны А/30 дугаар тушаал, ЭХЗХ-ны 2021 оны 55 дугаар тогтоолоор Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 8,064.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 8,058.9 сая төгрөгөөр, 5.4 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,885.2 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

ТУЗ-ийн 2021 оны 23 дугаар тогтоол, ЭХС-ын 2021 оны А/170 дугаар тушаалаар Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг нийт орлогыг 10,103.3 сая, нийт зардлыг 10,100.2 сая, үүнээс хөрөнгө оруулалтын 23 арга хэмжээг 3,255.4 сая төгрөгөөр тус тус тодотгон 3.1 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 10,233.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 7,760.0 сая төгрөгийн зардал гарган, 2,473.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 10,233.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 130.3 сая төгрөг буюу 101.3 хувиар давсан нь үндсэн бус үйл ажиллагааны орлого төлбөртэй үйлчилгээний орлого нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 7,760.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,340.2 сая төгрөг дутуу буюу 76.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь хөрөнгө оруулалтын өгөөж 1,242.8 сая, тайлант оны ажлын үр дүнг дүгнээгүй тул жилийн үр дүнгийн урамшуулалт цалинг хойшлуулсан 416.5 сая төгрөгийн дутуу зарцуулалттай, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж цалин, нийгмийн хамгааллын арга хэмжээ, харилцаа холбоо, албан томилолтын зардлуудыг 680.9 сая төгрөгийн бодит хэмнэлттэй зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 23 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 3,194.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 2,189.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,186.5 сая төгрөгөөр илүү байгаа нь үндсэн бус үйл ажиллагааны орлого 150.0 сая төгрөгөөр давж биелсэн, зардал 2,340.2 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь нөлөөлж байна.

ТӨБЗГ-ын 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 228 дугаар тогтоолын дагуу тайлант онд ашгийн 30.0 хувь буюу 37.8 сая төгрөгийн ногдол ашгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК нь тайлант онд нийт 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хугацаанд нь бүрэн байршуулж мэдээлсэн байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд хийгдсэн худалдан авах ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн эсэхийг тендерийн анхан шатны баримт материалтай тулган шалгахад зөрчилгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, ТБОНӨХБАҮХА тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 16,675.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 16,666.7 сая төгрөгийг залруулж, 8.9 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгалаа. Үүнд:

- Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 9.6 сая, ерөнхий ба удирдлагын зардалд 0.7 сая, борлуулалт маркетингийн зардалд 12.8 сая, нийт 23.1 сая төгрөгийн зардлуудыг өртгийн төвөөр хуваарилаагүй;
- Нэмэлт ажил үйлчилгээний орлогод хамаарах 9.6 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлыг бүртгээгүй, цэвэр ашгийг зөв тооцоолоогүй, 2.2 сая төгрөгийн цалингийн зардлыг илүү олгосон, нийт 11.8 сая төгрөгийн ашгийг илүү хуваарилсан;
- Экспорт импорт, нэг худалдан авагчийн загварын болон нэгтгэл тайлангуудад 63.3 сая төгрөгийн валютын ханшийн зөрүүг бодит, бодит бусаар ангилан бүртгээгүй;
- Хяналтын тооллогоор 2021 оны 8 дугаар сард шинээр авсан нийт 29.4 сая төгрөгийн 11 ширхэг компьютер бүртгэлийн кодгүй, 33.5 сая төгрөгийн 13 ширхэг хуучин компьютерын код арилсан, гэрээр ажиллаж байгаа ажилтнуудын 9 ширхэг 18.5 сая төгрөгийн зөөврийн компьютерыг хөрөнгийн тооллогод хамруулаагүй, үндсэн хөрөнгийн журналд 2 ажилтны компьютер бүртгэлгүй, 2 ажилтны компьютерын шилжилт хөдөлгөөн хийгдээгүй нийт 81.4 сая төгрөгийн зөрчил;
- Анхан шатны баримтаар нотлогдоогүй томилолтын зардал 1.1 сая төгрөгийг урьдчилгаа цалинд хааж, 1 ажилтнаас дутуу суутгасан ХХОАТ 0.2 сая, НДШ 0.3 сая, нийт 1.6 төгрөгийг ажиллагсдаас авах авлага үүсгэн бүртгээгүй;
- Шатахууны зарцуулалтад норм мөрдөөгүй 0.3 сая, албан томилолтын зардалд анхан шатны баримтын бүрдэлгүй 0.4 сая, нийт 0.7 сая төгрөгийг ажиллагсдаас авах авлага үүсгэн бүртгээгүй;
- ЭХЗХ-нд нэг худалдан авагчийн загварын тооцооны мэдээг сар бүр гарган хянуулж байгаа боловч мэдээ тайланд үндэслэн жилийн дундуур тарифыг үндэслэлтэй баталж мөрдүүлээгүйгээс тайлант оны 3 дугаар улирлын байдлаар 16,484.8 сая төгрөгийн эерэг зөрүү тайлагнасан.

Өртөг зардлуудыг өртгийн төвүүдээр хуваарилаагүй, нэмэгдэл ажил үйлчилгээний зардлыг бүрэн бүртгээгүй, цэвэр ашгийг зөв тооцоолон бүртгээгүй алдааг жилийн эцсийн аудитад залруулсан боловч нягтлан бодох бүртгэл, тайлагналын үйл ажиллагааг сайжруулах талаар 2 зөвлөмжийг аудитын илрүүлэлтэд оруулав.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 21.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 8,125.9 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 2,818.8 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгснөөс акт, албан шаардлага 100.0 хувь биелүүлж, 170.4 сая төгрөгийн 1 зөвлөмжийг биелүүлээгүй, 93.9 хувийн биелэлттэй давтан зөрчил гаргасан байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	2	21.0	2	21.0	-	-	100.0
Албан шаардлага	3	8,125.9	3	8,125.9	-	-	100.0
Зөвлөмж	4	2,818.8	3	2,648.4	1	170.4	93.9
Нийт дүн	9	10,965.7	8	10,795.3	1	170.4	98.4

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлттэй холбоотой өгсөн 170.4 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжилт хангалтгүй байна. Өмнөх онд төсвийн төлөвлөлтийг оновчтой

болгох талаарх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчил давтан гаргасан асуудалд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолыг үндэслэн ЭХС-ын 2020 оны 269 дүгээр тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ын 6 дугаар зүйлийн дагуу 2021 онд айл өрх, зарим аж ахуйн нэгжийн цахилгаан, дулааны эрчим хүчний төрөөс даах төлбөр 745.4 сая төгрөгийн санхүүжилт Сангийн яамнаас хүлээн авч ЭХЗХ-ны баталсан жагсаалтын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад шилжүүлсэн байна. Засгийн газрын дээрх дэмжлэг нь 2020 оны 12 дугаар сараас 2022 оны 6 дугаар сар хүртэлх хугацааг хамрах бөгөөд ДҮТ ТӨХХК нь тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудтай дээрх төлбөр тооцоог баталгаажуулж дуусаагүй байгаа тул эцсийн тайланг дараагийн аудитаар авч үзнэ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 950.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 646.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 294.8 сая төгрөгийн 3 алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 950.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 8,986.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Төлбөрийн акт

ДҮТ ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын 2021 оны Б/98 дугаар тушаалаар бүтэц орон тоо шинэчлэн баталсан байна. Дээрх тушаалд батлагдаагүй албан тушаалыг 4 ажилтанд хавсран гүйцэтгүүлж, дээд байгууллагын шийдвэргүй 8.9 сая төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь ТБОНӨТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.4-д “үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох”, МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.3-д “... төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх ...” гэсэн заалттай нийцээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

8.2 Албан шаардлага

Тайлант оны нэмэлт ажил үйлчилгээний орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс 127.6 сая төгрөгөөр давсан, 2019 оны төсөвт батлагдсан ч хэрэгжүүлээгүй 102.0 сая төгрөгийн зардлыг тайлант оны төсөвт тодотгоогүй зарцуулсан, 2022 онд дүгнэх жилийн үр дүнгийн урамшуулалт цалин 416.5 сая төгрөгийн зардлыг тайлант оны төсөвт оруулан төлөвлөсөн нь өмнөх онд төсвийн төлөвлөлтийг оновчтой болгох талаарх өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.4-т “санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашгийг төлөвлөж батлуулахаар хүргүүлэх”, 4.2-т “төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах” гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Өртөг, зардлуудад өртгийн төвөөр хуваарилаагүй зардлуудыг бүртгэсэн, шинэчлэгдсэн бүтэц зохион байгуулалтын дагуу өртгийн төвүүд, тэдгээрт хамаарах дансыг санхүүгийн программд шинэчлээгүй, НБББББ-т өөрчлөлт оруулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” заалттай нийцээгүй ангилал болон ойлгомжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

1.2 Өгсөн зөвлөмж:

Шинэчлэгдсэн бүтэц зохион байгуулалтын дагуу НБББББ-д зардлын чиг үүргүүдэд хамрах өртгийн төвүүдийн дансны жагсаалтыг шинэчлэх, бодлого горимуудыг тодорхой болгож, санхүүгийн программыг уялдуулан өөрчлөх.

2. Дүрэм журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Нэмэлт ажил үйлчилгээний зардлыг тусад нь хуримтлуулан бүртгээгүй, захирлын зөвлөлд танилцуулж батлуулсан цэвэр ашгийн тооцооллыг аудитад танилцуулаагүй, цэвэр ашгийн хуваарилалтыг баталсан шийдвэр ирүүлээгүй нь холбогдох журмын хэрэгжилт хангалтгүй, цэвэр ашгийн хуваарилалтад бүртгэлээр тавих хяналт сул байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, ДҮТ ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 15 дугаар тогтоолоор баталсан “Нэмэлт ажил үйлчилгээ зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2-д “Тухайн гэрээт ажилд шаардлагатай зардлыг тус ажил үйлчилгээний орлогоос санхүүжүүлэх ба санхүүгийн нэгж цэвэр ашгийг тодорхойлно. Санхүүгийн нэгж нь зардлын холбогдох баримтыг бүрдүүлж, ашиглагдсан биет болон биет бус хөрөнгийн элэгдлийг тооцон, цэвэр ашгийн тодорхойлолтыг дэлгэрэнгүй тайлбарын хамт захирлын зөвлөлийн хуралд танилцуулна” заалттай нийцээгүй эрх ба үүрэг, үнэн зөв ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна;

2.2 Өгсөн зөвлөмж:

Нэмэлт ажил үйлчилгээний гэрээ бүрд ногдох зардлын гүйцэтгэлийг бүртгэх, холбогдох зардлын дансыг нээж бүртгэлд ашиглах, цэвэр ашгийн тооцооллыг удирдлагад танилцуулан шийдвэр гаргуулах

3.Татварын өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулахтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд НӨАТ-ын илүү төлөлтийн авлагыг татварын цахим хуудаст бүртгэгдсэн үлдэгдлээс 294.8 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалттай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Татварын үлдэгдлийг татварын байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулан тайланд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөм-жийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
							тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	ДҮТ ТӨХХК	АХГ-2022/101/НА-СТА-ТӨА	ДҮТ ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын 2021 оны Б/98 дугаар тушаалаар бүтэц орон тоо шинэчлэн баталсан байна. Дээрх тушаалд батлагдаагүй албан тушаалд 4 ажилтныг хавсран гүйцэтгүүлж, дээд байгууллагын шийдвэргүй 8,964.3 мянган төгрөгийн цалин олгосон байна.	Улсын төсөвт төвлөрүүлэх	1	8,964.3					1	8,964.3				
2	ДҮТ ТӨХХК	АХГ-2022/101/НА-СТА-ТӨА	Тайлант оны нэмэлт ажил үйлчилгээний орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс 127.6 сая төгрөгөөр хэтэрсэн, 2019 оны төсөвт батлагдсан ч хэрэгжүүлээгүй 102.0 сая төгрөгийн зардлыг тайлант оны төсөвт тодотгоогүй зарцуулсан, 2022 онд дүгнэх жилийн үр дүнгийн урамшуулалт цалин 416.5 сая төгрөгийн зардлыг тайлант оны төсөвт оруулан төлөвлөсөн нь өмнөх онд төсвийн төлөвлөлтийг оновчтой болгох талаарх өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна	Төсвийг бодитой, оновчтой төлөвлөж гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах	1	646,318.4					1	646,318.4				
3	ДҮТ ТӨХХК	АХГ-2022/101/НА-СТА-ТӨА	Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 9.6 сая, ерөнхий ба удирдлагын зардалд 0.7 сая, борлуулалт маркетингийн зардалд 12.8 сая, нийт 23.1 сая төгрөгийн зардлуудыг өртгийн төвөөр хуваарилаагүй, бүртгээгүйг аудитын явцад залруулсан ч шинэчлэгдсэн бүтэц зохион байгуулалтын дагуу өртгийн төвүүд, тэдгээрт хамаарах дансыг санхүүгийн программд шинэчлээгүй, НБББББ-т өөрчлөлт оруулаагүй байна.	Өртөг, зардлыг зөв хуваарилан бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх	1	-								1	-	
4	ДҮТ ТӨХХК	АХГ-2022/101/НА-СТА-ТӨА	Нэмэлт ажил үйлчилгээний орлогод хамаарах зардлуудыг тухайн гэрээний гүйцэтгэлд хамааруулан бүртгээгүй, цэвэр ашгийг зөв тооцоолоогүй, удирдлагад зориулсан тооцооллыг бэлтгэж танилцуулаагүй, цэвэр ашгийн хуваарилалтад бүртгэлээр тавих хяналт сул байна.	Цэвэр ашгийг зөв хуваарилах, зардлыг давхардуулах-гүйгээр байгууллагын ашгийг нэмэгдүүлэх	1	-								1	-	

5	ДҮТ ТӨХХК	АХГ- 2022/101/ НА-СТА- ТӨА	Нийслэлийн татварын газраас НӨАТ-ын илүү төлөлтийн дүнг тайланд татварын сайтад бүртгэгдсэн үлдэгдлээс 294.8 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан. Шалгагдагч байгууллагын татварын тодорхойлолт гаргуулан тулгахад зөрүүтэй байсан тул тулган баталгаажуулах захидал бэлтгэн илгээж, аудитын хугацаанд татварын газраас хариу ирүүлээгүй	Татварын алданги торгуулиас урьдчилан сэргийлэх	1	294,794.5									1	294,794.5
ДҮН					5	950,077.2			1	8,964.3	1	646,318.4			3	294,794.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 325/AD150055
АХГ-2022/101/МА СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны нэмэлт ажил, үйлчилгээний орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс 127,783,827.95 төгрөгөөр хэтэрсэн, 2019 оны төсөвт батлагдсан ч хэрэгжүүлээгүй 102,034,825.00 төгрөгийн зардлыг тайлант оны төсөвт тодотгоогүй зарцуулсан, 2022 онд дүгнэх жилийн үр дүнгийн урамшуулалт цалин 416,450,766.60 төгрөгийн зардлыг тайлант оны төсөвт оруулан төлөвлөсөн нь өмнөх онд төсвийн төлөвлөлтийг оновчтой болгох талаарх өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 21^{1.2.4} “санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг”, 21 дүгээр зүйлийн 21.4.2 “төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөвлөлтийг оновчтой хийгээгүй, гарсан өөрчлөлтийг тодотгон батлуулаагүй, үр дүнг бодитой гаргаж, байгууллагын үр ашгийг зөв тооцоогүй зөрчлийг арилгах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Балжинням, санхүүгийн ажилтан Т.Бямбажав нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Н.ДЭЛГЭРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 63/AOISO055
АХГ-2022/101/МА-СТА-ТӨА
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар тогтоол, гүйцэтгэх захирлын 2021 оны Б/98 дугаар тушаалаар бүтэц, орон тоог шинэчлэн баталсан байна. Энэхүү тушаалаар батлаагүй албан тушаалыг 4 ажилтнаар хавсран гүйцэтгүүлж, дээд байгууллагын шийдвэргүй 8,964,307.21 төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 "үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.3 "... төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх ..." гэсэн заалттай нийцээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Батлагдаагүй албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж олгосон 8,964,307.21 /найман сая есөн зуун жаран дөрвөн мянга гурван зуун долоон төгрөг хорин нэгэн мөнгө/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банк дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Балжинням, нягтлан бодогч Т.Бямбажав нарт даалгав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

(Handwritten signatures and red stamps)

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Н.ДЭЛГЭРМАА

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0315 Auditin 4 Gazar-1.Docx

001030197

